



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№255 /464/

2023.01.27

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦУГЛАРАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цуглалалт энэ сарын 26-27-ны өдрүүдэд ҮБХИС-ийг түшиглэн амжилттай зохион байгуулагдлаа.

Цуглалалтын эхний өдөр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар цуглалалтад оролцож буй бие бүрэлдэхүүнд хандан зарим үүрэг, чиглэлийг өгсөн бол үргэлжлүүлэн Цэргийн штабын дарга

нар өнгөрсөн жилийн үйл ажиллагааны тайлан болон энэ онд хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, тулгамдсан асуудлуудаа хэлэлцсэн юм.

Тэгвэл өнөөдөр Цэргийн штабын дарга нар БИЦУГ, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын Удирдлагын академи, номын сангийн үйл ажиллагаатай танилцсаны зэрэгцээ өөрсдийн харьяа аймгуудаас ҮБХИС-д элсэн суралцаж буй сонсогчидтой уулзаж, дурсгалын зургаа

татууллаа. Энэ үеэр БИЦУГ-ын дарга хурандаа Х.Батсайхан нийт бие бүрэлдэхүүнд БИЦУГ-ын тухай товч танилцуулгыг хийж, асуусан асуултад хариулсан юм.

Төгсгөлд нь ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд зориулсан урлагийн хэсэгчилсэн тоглолтоо өргөн бариллаа.

**Ө.НАСАНТОГТОХ**



## ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН НЭГТГЭЛ, АНГИЙН ЗАХИРАГЧ НАРЫН ЦУГЛАРАЛТААР

Зэвсэгт хүчний Жанжин штабаас Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний 2023 оны стратегийн цуглалалтыг энэ сарын 23-25-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан билээ.

Тэгвэл Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын захирагч нарын цуглалалт Хуурай замын цэргийн командлалд энэ сарын 26-ны өдөр үргэлжлэн явагдав.

Цуглалалтыг нээж Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Ц.Буяндэлгэр үг хэлсэн бөгөөд тэрээр

2023 онд нэгтгэл, ангиудад явагдах арга хэмжээ болон бэлэн байдал, штабын бэлтгэлжилт, цэргийн алба, сахилга хариуцлагын талаар мэдээлэл хүргэж, үүрэг чиглэл өглөө. Мөн тэрээр алба хаагчдынхаа бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтээс нь эхлээд хувь хүний хөгжилд нь зайлшгүй анхаар, алба хаагч бүрийн мэдлэг, дадлага, чадвараас Хуурай замын цэргийн хөгжил шууд хамааралтайг ухамсарлаж, аливаа ажил, арга хэмжээгээ зөв төлөвлөж явуулахыг захиж байсан юм.



Үргэлжлүүлэн командлалын хэлтсийн дарга нар удирдлага, төлөвлөлт, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн алба, материал техникийн хангалтын талаар захирагч нартай санал солилцож, харилцан ярилцав.

Цуглалалтын төгсгөлд Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал цэргийн сургалтад агуулгын өөрчлөлт хийх, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар болон манлайллыг дээшлүүлэх, хандлага,

бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, нийгмийн хамгаалал, алба хаах орчин нөхцөлийг сайжруулах, жишиг ногоон хотхон төсөл хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдалд анхаарах зэрэг олон асуудлаар үүрэг чиглэл өгч, ажил албанд нь өндөр амжилт хүслээ.

Энэ үеэр мөн захирагч нартай Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, баталсан юм.  
**Гэрэл зургийг О.МӨНХБАТ**

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| -15  | -26  |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 40   | 25   |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ  | ЗАРАХ |
|-------|-------|-------|
| USD   | 3,500 | 3,507 |
| EUR   | 3,820 | 3,845 |
| CNY   | 519   | 522   |
| RUB   | 49.10 | 49.50 |
| JPY   | 27.20 | 27.40 |
| KRW   | 2.86  | 2.89  |

ЗУРХАЙ

2023.01.27 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 6

**ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Өнгө зүс сайжирна**  
**Наран ургах, шингэх:**  
08.26-17.43  
**Барилдлага:**  
Идэр  
**Шүтэн барилдлага:**  
Хүрэлцэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 674,405,822

Эдгэрсэн

Нийт: 646,395,214

Нас барсан

Нийт: 6,755,673

Цахим шууданд

## БАЙЛДАГЧ Г.ТӨГӨЛДӨР УЛСЫН АВАРГААС ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



байгуулагдсан "UNC-2023" улсын аварга шалгаруулах тэмцээний байт харвааны U21 насны ангилалд багаараа хүрэл медаль хүртэж, "Мэргэнбайлдагч" хэмээн зохион байгуулагчдаас өндөр үнэлгээ авсан байна. Энэхүү тэмцээнийг 15 спорт холбоо нэгдэж зохион байгуулсан бөгөөд байт харвааны төрөлд 3 насны ангиллаар 15 байгууллагын 166 тамирчин цэц мэргэнээ сорин өрсөлджээ.

Байлдагч Г.Төгөлдөрийн баярын сэтгэгдлийг хуваалцахад "2019 оноос байт харваагаар хичээллэж байна. "Эрч" клубын тамирчин. Саяхан болж өнгөрсөн тэмцээнд манай клубын М.Төгөлдөр, М.Чингүүн бид гурав U21 насны багийн төрөлд хүрэл медаль хүртсэндээ баяртай байна. Миний хувьд 2019 онд ганцаарчилсан болон багийн төрлөөр мөнгө, хүрэл медаль хүртэж байсан. Тэмцээний өмнө бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлсэн ангийнхаа удирдлага, хамт олонд талархал илэрхийлье. Байт харваа нь анхаарал, төвлөрөл, сэтгэл хөдлөлөө барих чадварыг хөгжүүлдэг спорт" гэсэн юм.

Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч А.Амар цэргийн албанаас их сургуулиа дүүргэсэн мэдээтэй залгуулаад өөр нэг байлдагчийн амжилтын мэдээ бидэнд ирлээ.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Г.Төгөлдөр энэ сарын 16-18-ны өдрүүдэд зохион

## "АХЛАГЧ БИДНИЙ ҮЛГЭРЛЭЛ, МАНЛАЙЛАЛ ӨӨРСДӨӨС ШАЛТГААЛНА"



Зэвсэгт хүчний 120 дугаар анги нь бие бүрэлдэхүүндээ манлайлал, итгэл үнэмшил, харилцаа хандлага, өөрчлөлт шинэчлэл сэдвээр сургалтуудыг зохион байгуулж байгаагийн нэг нь сар тутам явагддаг "Ахлагчийн өдөр" юм.

Нэгдүгээр сарын алба сурталчлах өдөрлөгийг Артиллерийн дивизионы ахлагч нар хариуцсан бөгөөд тэд "Эерэг хандлагыг түгээе" ярилцлага болон хамт олны халуун дулаан уур амьсгалыг бэхжүүлэх хүрээнд хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулсан юм.

Ангийн ахлагч, тэргүүн ахлагч Г.Алтанбагана "Ахлагч бидэнд нэн

тэргүүний зорилт бол хариуцсан албаа нэр төртэй гүйцэтгэх билээ. Бүтээлч, санаачилгатай, харилцаа хандлагаараа эерэг манлайлагч ахлагч болох нь зөвхөн биднээс шалтгаална. Энэ бол та бидний үнэнч байдал, хичээл зүтгэл юм" гээд сар бүр манлайлагч ахлагчийг тодруулж, бусдад нь үлгэрлэл үзүүлэхээр төлөвлөснөө онцоллоо. Нэгдүгээр сарын манлайлагчаар ахлах ахлагч Ц.Эрдэнэхуяг, ахлагч А.Энхбат нар шалгарч, талархал гардан юм. Хоёрдугаар сарын "Ахлагчийн өдөр"-ийг Тийрэлтэт артиллерийн дивизионыхон зохион байгуулна.

Хошууч Ө.НАРАНТУЯА



## ЦЭРГИЙН ЧУУЛГААР...



Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын дарга хурандаа Г.Золзаяа Батлан хамгаалахын сайд, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаал шийдвэр, шинэ сургуулийн жилийн зорилго, зорилт, удирдлагын баримт бичгийн хэрэгжилтийн талаар нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгч, үүрэг чиглэлээр хангалаа.

Чуулгын хамт олон шинэ оны эхний сард хийхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдээ амжилттай хэрэгжүүлж, удирдлага төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулалт, төрийн албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийх, БХЯ, ЗХЖШ, түүний харьяа байгууллагуудын захиалгат

арга хэмжээнүүдэд хэсэгчилсэн тоглолтуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хангасан өрнүүн ажлын сар байсан юм.

Ирэх сард бид "Монгол ёс заншлыг сурталчлах, соёлын өвийг түгээх сар"-ын ажлын хүрээнд Сар шинийн баярыг угтсан томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлэх зорилт тавин ажиллах болно.

ЦДБЭЧ-ын даргын "Сарын ажлыг дүгнэх тухай" тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсны дараагаар "Цэргийн тангараг" давтах, Төрийн дууллаа дуулах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгууллаа.

## ЖУДО БӨХИЙН УАШТ-Д



Жудо бөхийн 2023 оны насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Монгол бөхийн өргөөнд 1 дүгээр сарын 14-нөөс 16-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 34 байгууллага, клубийн 283 тамирчин оролцсон. Тус тэмцээнд Алдар спорт хорооны баг

тамирчид 4 алт, 4 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцож багаараа тэргүүн байр эзэллээ. Тэмцээний 3 дахь өдөр Холимог багийн 9 дэх удаагийн Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнд 12 баг орсноос "Алдар" спорт хорооны баг тэргүүлж тэргүүн байр эзэллээ.